



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Могод сумын ЭМТ-ийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БУА-2022/53/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Булган аймаг 2022 он</p>	<p>Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр Утас:70342580 Цахим хаяг: Ankhbayard@audit.gov.mn Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 70342716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn Ахлах аудитор: П.Мөнхтуяа Утас: 70342716 Цахим хаяг: MonkhtuyaP@audit.gov.mn Аудитор: Утас: 70342716 Цахим хаяг:</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	5-22
3. Аудитын тайлан.....	22-25
3.1 Ерөнхий зүйл.....	
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	
3.4 Материаллаг байдал.....	
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	
3.8 Аудитын гол асуудал.....	
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	
4. Аудитын илрүүлэлт.....	26-27
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	27

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан
ЭМГ	Эрүүл мэндийн газар
ЭМТ	Эрүүл мэндийн төв



**БУЛГАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-3259
E-mail: bulgan@audit.gov.mn

додд ор-16 № 89
танай _____ ны № _____ т

МОГОД СУМЫН ЭМТ-ИЙН
ДАРГА Г.БУЛГАН ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Могод сумын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Могод сумын ЭМТ-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  ДАНБАЯР

006020147

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>30,846,978.23</u>	<u>187,840,844.58</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	13,343,602.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	13,343,602.00
3121	Төгрөг	-	13,343,602.00
31211	Төрийн сангийн харилцах	-	6,970,060.97
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	-	6,373,541.03
33	АВЛАГА	-	54,355,200.00
335	Бусад авлага	-	54,355,200.00
3351	Байгууллагаас авах авлага	-	54,355,200.00
35	БАРАА МАТЕРИАЛ	30,846,978.23	120,142,042.58
351	Түүхий эд материал	8,091,174.15	29,444,125.50
35130	Эм боох материал	8,091,174.15	29,444,125.50
354	Хангамжийн материал	22,755,804.08	90,697,917.08
35410	Бичиг хэргийн материал	1,729,680.00	1,933,180.00
35420	Аж ахуйн материал	9,011,130.08	29,745,280.08
35430	Сэлбэг хэрэгсэл	2,636,500.00	2,636,500.00
35440	Түлш, шатах тослох материал	-	660,000.00
35460	Хүнсний материал	2,592,544.00	2,468,421.00
35470	Бусад хангамжийн материал	6,785,950.00	53,254,536.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>602,332,793.05</u>	<u>604,547,961.66</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	602,332,793.05	604,547,961.66
392	Биет хөрөнгө	583,068,793.05	585,343,961.66
39201	Барилга, байгууламж, орон сууц	504,584,955.34	504,584,955.34
39202	Хуримтлагдсан элэгдэл	(26,602,452.54)	(55,576,350.42)

Могод сумын ЭМТ-ийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

39203	Авто-тээврийн хэрэгсэл	69,090,667.00	69,090,667.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(12,352,544.07)	(24,264,544.35)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	72,712,337.60	128,807,532.96
39206	Хуримтлагдсан элэгдэл	(37,575,355.74)	(46,736,611.29)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	25,155,969.00	25,155,969.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(12,676,003.25)	(15,732,304.45)
39214	Бусад үндсэн хөрөнгө	12,120,000.00	12,120,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(11,388,780.29)	(12,105,352.13)
393	Биет бус хөрөнгө	19,264,000.00	19,204,000.00
39301	Програм хангамж	300,000.00	300,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(240,000.00)	(300,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	19,204,000.00	19,204,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>633,179,771.28</u>	<u>792,388,806.24</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>161,598.82</u>	<u>-</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	161,598.82	-
413	Өглөг	161,598.82	-
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	161,598.82	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>633,018,172.46</u>	<u>792,388,806.24</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	633,018,172.46	792,388,806.24
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	156,185,903.37	156,185,903.37
51101	Өмч: - төрийн	19,204,000.00	19,204,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	273,102,505.93	432,473,139.71
51210	Өмнөх үеийн үр дүн	273,102,505.93	273,102,505.93
51220	Тайлант үеийн үр дүн	-	159,370,633.78
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	203,729,763.16	203,729,763.16
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>633,179,771.28</u>	<u>792,388,806.24</u>

СТ-2А

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	514,763,709.67	950,977,023.44
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	448,225,009.67	221,449,901.48
120	Нийтлэг татварын бус орлого	99,228,009.67	221,449,901.48
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	99,228,009.67	221,449,901.48
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	99,228,009.67	221,449,901.48
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	348,997,000.00	-
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	348,997,000.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	66,538,700.00	729,527,121.96
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	34,373,000.00	386,549,342.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	34,373,000.00	-
131004	Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх	-	3,655,002.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	-	382,894,340.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	13,019,400.00	209,583,410.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	13,019,400.00	209,583,410.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	62,302,311.96
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	62,302,311.96
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	19,146,300.00	71,092,058.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	19,146,300.00	71,092,058.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	437,267,714.58	791,606,389.66
21	УРСГАЛ ЗАРДАЛ	437,267,714.58	791,606,389.66
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	434,591,419.01	760,306,389.66
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	283,260,580.84	353,087,513.00
210101	Үндсэн цалин	180,907,143.64	220,680,544.87
210102	Нэмэгдэл	84,450,996.72	89,420,987.23

Могод сумын ЭМТ-ийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	3,916,885.26
210104	Урамшуулал	17,902,440.48	39,069,095.64
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	37,170,512.59	45,320,470.18
210201	Тэтгэврийн даатгал	25,840,112.59	33,303,156.73
210202	Тэтгэмжийн даатгал	2,832,600.00	2,888,660.10
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,450,800.00	2,475,101.23
210204	Ажилгүйдлийн даатгал	381,800.00	583,749.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,665,200.00	6,069,803.12
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	31,303,131.00	31,771,911.96
210301	Гэрэл, цахилгаан	2,245,070.00	2,170,179.00
210302	Түлш, халаалт	28,903,731.00	29,496,232.96
210303	Цэвэр, бохир ус	154,330.00	105,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	17,436,690.00	21,287,090.00
210401	Бичиг хэрэг	2,350,600.00	2,388,000.00
210402	Тээвэр, шатахуун	9,988,420.00	13,973,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,486,680.00	1,815,590.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,219,810.00	2,984,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	21,900.00	125,700.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	2,369,280.00	-
2105	Нормативт зардал	38,020,235.38	245,043,305.77
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	32,940,234.88	236,282,058.77
210502	Хоол, хүнс	5,080,000.50	8,201,247.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	560,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	701,150.00	1,100,300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	59,100.00
210604	Урсгал засвар	701,150.00	1,041,200.00
2107	Томилолт, зочны зардал	1,373,000.00	648,000.00

Могод сумын ЭМТ-ийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210702	Дотоод албан томилолт	1,373,000.00	648,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,556,860.00	2,508,722.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	674,860.00	946,722.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	882,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	-	70,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	61,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	40,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	1,350,000.00
210807	Газрын төлбөр	-	40,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	23,769,259.20	59,539,076.75
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	631,920.00	5,659,050.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	23,137,339.20	53,880,026.75
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,676,295.57	31,300,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,200,000.00	31,300,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	22,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,200,000.00	9,300,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,476,295.57	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,476,295.57	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>77,495,995.09</u>	<u>159,370,633.78</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.16	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	0.16	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(0.16)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>77,495,994.93</u>	<u>159,370,633.78</u>

СТ-2А

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
------------	----------	---------------------	-----------------------

	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	415,535,700.00	675,171,921.96
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	348,997,000.00	-
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	348,997,000.00	-
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	348,997,000.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	66,538,700.00	675,171,921.96
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	34,373,000.00	386,549,342.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	34,373,000.00	-
131004	Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх	-	3,655,002.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	-	382,894,340.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	13,019,400.00	209,583,410.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	13,019,400.00	209,583,410.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	62,302,311.96
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	62,302,311.96
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	19,146,300.00	16,736,858.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	19,146,300.00	16,736,858.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	415,535,700.00	615,208,019.96
21	УРСГАЛ ЗАРДАЛ	415,535,700.00	615,208,019.96
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	412,859,404.43	583,908,019.96
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	283,260,580.84	353,086,613.00
210101	Үндсэн цалин	180,907,143.64	220,679,644.87
210102	Нэмэгдэл	84,450,996.72	89,420,987.23
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	3,916,885.26
210104	Урамшуулал	17,902,440.48	39,069,095.64
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	37,170,512.59	45,320,470.18
210201	Тэтгэврийн даатгал	25,840,112.59	33,337,203.73
210202	Тэтгэмжийн даатгал	2,832,600.00	3,089,125.78
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,266,100.00	2,475,101.23

Могод сумын ЭМТ-ийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210204	Ажилгүйдлийн даатгал	566,500.00	583,749.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,665,200.00	5,835,290.44
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	31,088,131.00	32,431,911.96
210301	Гэрэл, цахилгаан	2,245,070.00	2,170,179.00
210302	Түлш, халаалт	28,676,231.00	30,156,232.96
210303	Цэвэр, бохир ус	166,830.00	105,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	16,650,660.00	32,391,840.00
210401	Бичиг хэрэг	1,050,000.00	1,251,900.00
210402	Тээвэр, шатахуун	9,794,980.00	13,973,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,486,680.00	1,815,590.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,822,500.00	2,783,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,496,500.00	12,567,650.00
2105	Нормативт зардал	32,828,430.00	107,146,112.82
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	27,633,180.00	97,554,988.82
210502	Хоол, хүнс	4,460,250.00	6,588,124.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	735,000.00	3,003,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,655,430.00	2,556,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,484,000.00	730,000.00
210604	Урсгал засвар	3,171,430.00	1,826,500.00
2107	Томилолт, зочны зардал	1,373,000.00	648,000.00
210702	Дотоод албан томилолт	1,373,000.00	648,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,533,860.00	2,568,722.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,651,860.00	1,006,722.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	882,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	-	70,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	61,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	40,000.00

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	1,350,000.00
210807	Газрын төлбөр	-	40,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,298,800.00	7,757,850.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,298,800.00	7,757,850.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,676,295.57	31,300,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,200,000.00	31,300,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	22,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,200,000.00	9,300,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,476,295.57	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,476,295.57	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-	59,963,902.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	46,620,300.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	46,620,300.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	46,620,300.00
222001	Тоног төхөөрөмж	-	46,620,300.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-	(46,620,300.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	13,343,602.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	13,343,602.00

СТ-4А

ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	-	-	-
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-

C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-	-
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	-	-	-
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	-	-	-
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	156,185,903.37	203,729,763.16	273,102,505.77	-	633,018,172.30
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-	-
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	159,370,633.78	-	159,370,633.78
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	156,185,903.37	203,729,763.16	432,473,139.55	-	792,388,806.08

ТГ

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

	Үзүүлэлт	Өмнөх оны	Тайлант оны
--	----------	-----------	-------------

Могод сумын ЭМТ-ийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Эдийн засгийн ангилал		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	411970000.00	415535700.00	479056900.00	454963448.99
21	УРСГАЛ ЗАРДАЛ	411970000.00	415535700.00	479056900.00	449123448.99
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	410970000.00	412859404.43	478056900.00	448223448.99
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	283260800.00	283260580.84	312656900.00	306878324.20
210101	Үндсэн цалин	182071700.00	180907143.64	187757200.00	195106790.37
210102	Нэмэгдэл	82981900.00	84450996.72	96824800.00	85385552.93
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	0.00	5544000.00	3916885.26
210104	Урамшуулал	18207200.00	17902440.48	22530900.00	22469095.64
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	38240200.00	37170512.59	42208700.00	39563112.01
210201	Тэтгэврийн даатгал	26909800.00	25840112.59	29702400.00	27579845.56
210202	Тэтгэмжийн даатгал	2832600.00	2832600.00	3126600.00	3089125.78
210203	ҮОМШӨ-ний даатгал	2266100.00	2266100.00	2501200.00	2475101.23
210204	Ажилгүйдлийн даатгал	566500.00	566500.00	625400.00	583749.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5665200.00	5665200.00	6253100.00	5835290.44
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	32860000.00	31088131.00	38529900.00	32431911.96
210301	Гэрэл, цахилгаан	2540000.00	2245070.00	2540000.00	2170179.00
210302	Түлш, халаалт	29571000.00	28676231.00	35240900.00	30156232.96
210303	Цэвэр, бохир ус	749000.00	166830.00	749000.00	105500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	22513000.00	16650660.00	22813000.00	20639050.00
210401	Бичиг хэрэг	1050000.00	1050000.00	1350000.00	1251900.00
210402	Тээвэр, шатахуун	15653700.00	9794980.00	15653700.00	13710100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,486,800.00	1,486,680.00	1,486,800.00	1,449,890.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,822,500.00	2,822,500.00	2,822,500.00	2,783,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,500,000.00	1,496,500.00	1,500,000.00	1,443,760.00
2105	Нормативт зардал	21,080,000.00	32,828,430.00	40,770,000.00	39,138,582.82
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	10,110,000.00	27,633,180.00	29,800,000.00	29,547,458.82
210502	Хоол, хүнс	7,960,000.00	4,460,250.00	7,960,000.00	6,588,124.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,010,000.00	735,000.00	3,010,000.00	3,003,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,013,000.00	5,655,430.00	7,500,000.00	1,303,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,500,000.00	2,484,000.00	6,000,000.00	-

Могод сумын ЭМТ-ийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210604	Урсгал засвар	1,513,000.00	3,171,430.00	1,500,000.00	1,303,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,300,000.00	1,373,000.00	1,700,000.00	648,000.00
210702	Дотоод албан томилолт	2,300,000.00	1,373,000.00	1,700,000.00	648,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,571,000.00	2,533,860.00	6,703,000.00	2,568,722.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,689,000.00	1,651,860.00	4,689,000.00	1,006,722.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	882,000.00	882,000.00	432,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	-	-	70,000.00	70,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	-	61,500.00	61,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	-	40,000.00	40,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	-	1,350,000.00	1,350,000.00
210807	Газрын төлбөр	-	-	40,500.00	40,500.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	-	-	20,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,132,000.00	2,298,800.00	5,175,400.00	5,052,746.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,132,000.00	2,298,800.00	5,175,400.00	5,052,746.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,000,000.00	2,676,295.57	1,000,000.00	900,000.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	1,476,295.57	-	-
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	-	1,476,295.57	-	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,000,000.00	1,200,000.00	1,000,000.00	900,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	1,200,000.00	1,000,000.00	900,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	-	-	5,840,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	-	-	5,840,000.00
222001	Тоног төхөөрөмж	-	-	-	5,840,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	411,970,000.00	415,535,700.00	437,677,000.00	461,933,509.96
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	383,370,000.00	396,389,400.00	409,077,000.00	382,894,340.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	34,373,000.00	34,373,000.00	-	-
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	-	13,019,400.00	-	-
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	348,997,000.00	348,997,000.00	409,077,000.00	382,894,340.00

1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	-	-	62,302,311.96
132001	Орон нутгийн төсвөөс	-	-	-	62,302,311.96
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	28,600,000.00	19,146,300.00	28,600,000.00	16,736,858.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	28,600,000.00	19,146,300.00		
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	-	-	28,600,000.00	16,736,858.00

НТ-2

НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	206,864,870.97
21	УРСГАЛ ЗАРДАЛ	166,084,570.97
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	135,684,570.97
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	46,208,288.80
210101	Үндсэн цалин	25,572,854.50
210102	Нэмэгдэл	4,035,434.30
210104	Урамшуулал	16,600,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,757,358.17
210201	Тэтгэврийн даатгал	5,757,358.17
2104	Хангамж, бараа материалын зардал	11,752,790.00
210402	Тээвэр, шатахуун	263,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	365,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	11,123,890.00
2105	Нормативт зардал	68,007,530.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	68,007,530.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,253,500.00

210601	Багаж, техник, хэрэгсэл	730,000.00
210604	Урсгал засвар	523,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,705,104.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,705,104.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	30,400,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	30,400,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	22,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,400,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	40,780,300.00
2200	Дотоод эх үүсвэрээр	40,780,300.00
222001	Тоног төхөөрөмж	40,780,300.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	209,583,410.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	209,583,410.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	209,583,410.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Могод сумын ЭМТ-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд санхүүгийн тайлан, бүртгэлд гарсан алдаа зөрчилтэй, холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг аудитын газрын ахлах аудитор П.Мөнхтуяа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Могод сумын ЭМТ-ийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 01 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Могод сумын ЭМТ нь 2021 онд “Эмнэлгийн ажилтны ёс зүйн хэм хэмжээг сахисан, ээлтэй орчинд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг жигд хүртээмжтэй, чанартай үзүүлж, эрүүл боловсролыг тасралтгүй олгосноор эрүүл урт наслалтыг дэмжихэд оршино” гэсэн зорилго тавьж зорилгын хүрээнд 3 зорилтыг хэрэгжүүлж ажиллахаар төлөвлөжээ. Үүнд:

1. Эрүүл аж төрөх эрүүл мэндээ хамгаалах зөв зан үйлийг төлөвшүүлж өвчлөл нас баралтыг бууруулна.
2. ЭМ-ийн үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг чанаржуулан өвчлөлөөс урьдчилан сэрийлнэ.
3. Үйлчлэгчид үзүүлэх тусламж үйлчилгээг хөнгөн шуурхай чанартай болгож үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийг дээшлүүлнэ гэсэн зорилтуудыг тавьжээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагыг хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар болон дотоод аудитын нэгжгүй болно. Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Могод сумын ЭМТ-ийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт орлогын 514.7 сая төгрөгөөс 2 хувиар буюу 10.3 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 8.2 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Могод сумын ЭМТ нь 2021 оны санхүүгийн тайлангийн тодруулгыг Сангийн сайдын 388 дугаар журмын 3-р хавсралтын дагуу бэлтгэж тайлагнасан байна. Үүнд: Санхүү байдлын, Үр дүнгийн, Мөнгөн гүйлгээний, Өмчийн өөрчлөлтийн тайлангууд, санхүүгийн тодруулга тайлангуудын өөрчлөлт, нягтлан бодох бүртгэлийн зарчмыг баримтлан, НБББ, санхүүгийн болон үйл ажиллагааны үр дүнгийн талаар болзошгүй өр төлбөр, авлагыг зэргийг тодруулж тайлагнасан болно.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Могод сумын ЭМТ нь 2021 онд улсын төсвөөс 349.0, ЭМДС-гаас 28.6, орон нутгийн төсвөөс 34.4 сая төгрөг буюу нийт 412.0 сая төгрөгийн санхүүжилт авахаар төлөвлөсөн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тус сумын ЭМТ нь 2021 он улсын төсвөөс 382.9, орон нутгийн төсвөөс 62.3, ЭМДСангаас 16.7, нэмэлт дансаар 209.6, өөрийн үйл ажиллагааны орлогоос 3.7 сая төгрөг буюу нийт 675.2 сая төгрөгийн санхүүжилт авч гүйцэтгэлээр 661.9 сая төгрөгийг зарцуулж, мөнгөн гүйлгээний тайлангаар 13.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнажээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Могод сумын ЭМТ нь 2021 онд нэмэлт дансаар нийт 209.6 сая төгрөгийн санхүүжилт авч гүйцэтгэлээр 203.3 сая төгрөгийг зарцуулж 6.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнажээ. Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Могод сумын ЭМТ нь ковид буюу цар тахалтай холбогдуулаад ЭМС-ийн 2021 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн А/496, 2021 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн А/585 тоот тушаалуудыг үндэслэн тэтгэмж урамшуулалын зардалд 30.4 сая төгрөгийг олгосон байна. Хандив тусламжаар ЭМЯ болон ЭМГ-аас 9.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, 211.9 сая төгрөгийн бараа материалыг тус тус орлогод авч тайлагнажээ.

Хэвтэн эмчлүүлсэн, дархлаажуулалтын 54.3 сая төгрөгийн авлагыг санхүүгийн тодруулга тайланд бүрэн тусгаж өмнөх оны 0.1 сая төгрөгийн өглөгтийг бүрэн барагдуулж өглөгийн үлдэгдэлгүй тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй 55.7 сая төгрөгийн алдаа зөрчлийг залруулга хийх 2022 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 06 тоот албан бичгийн дагуу санхүүгийн тайланд залруулга хийж баталгаажууллаа.

3.8 Аудитын гол асуудал

Тус сумын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг баталгаажуулж ажиллахдаа аудитын төлөвлөлтийн үе шатанд сонгосон нийт 12 эрсдэлийн хүрээнд горим сорилыг хэрэгжүүлэн ажиллалаа.

Хэрэгжүүлсэн горим сорилоор тушаал шийдвэргүй тэтгэмж олгосон, нэг удаагийн буцалтгүй тэтгэмжийн зардлаас бараа материал худалдан авсан, жиилийн эцэст ашиглагдахгүй байгаа хөрөнгө материалыг акталж устгах ажлг зохион байгуулж ажиллаагүй, эмийн орлого, зарлагыг зөрүүтэй тайлагнасан, харилцагч байгууллагуудтай тооцоо нийлж ажиллаагүй, шилэн дансны мэдээллийг хугацаанд нь мэдээлээгүй хугацаа хоцроосон зэрэг зөрчлүүд илэрсэн.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Үүний дагуу байгууллагын мэдээллийг шилэн дансанд бүрэн мэдээлсэн боловч 10 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлжээ.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн заалттай нийцэж байгаа ч мэдээллийг цаг хугацаанд нь мэдээлээгүй нь холбогдох шалгуурт бүрэн нийцэхгүй байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх санхүүгийн тайлан баталгаажуулах аудитаар 3 зөвлөмж өгч ажилласнаас зөвлөмжийн хэрэгжилтийг 2021 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 29 тоот албан бичгээр хүргүүлж ажиллажээ.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тус сумын ЭМТ нь 2022 оноос эхлэн гүйцэтгэлээрээ санхүүжиж байгаатай холбогдуулан өөрийн үйл ажиллагааны орлого болон гүйцэтгэлийг дараагийн аудитаар шалгах асуудалд оруулах нь зүйтэй гэж үзэж байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 58.1 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, .0.8 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт, 0.9 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 0.7 сая төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгч 55.7 сая төгрөгийн алдааг залруулж ажиллалаа.

4.1 Залруулсан алдаа

Орлого үр дүнгийн тайланд 54.4 сая төгрөгийн орлого, мөнгөн гүйлгээний тайланд 0.6 сая төгрөгийг хөрөнгийг тус тус дутуу, 0.7 сая төгрөгийн зарлагын дансыг буруу илэрхийлсэнг НББ-ийн тухай 15 дугаар зүйлд заасны дагуу залруулга хийж баталгаажуулан ажиллалаа.

4.2 Төлбөрийн акт

1. Тус сумын ЭМТ-ийн 2021 оны тэтгэмж урамшууллын зардлыг түүвэрлэн шалгахад 400000 төгрөгийн тэтгэмжийг тушаал шийдвэргүйгээр олгосон зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.”, 13 дугаар зүйлийн 6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.”, 13 дугаар зүйлийн 7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.” гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Төлбөрийн акт бичлээ.

2. Тус сумын ЭМТ-ийн 2021 оны эмийн орлого, зарлагыг түүвэрлэн шалгахад 368030 төгрөгийн эмийн орлого дутуу, илүү шилжүүлсэн зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, НББ-ийн тухай хуулийн 13.1. “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.”, 13 дугаар зүйлийн 6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.”, гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь:
Төлбөрийн акт бичлээ.

4.3 Албан шаардлага

Тус сумын ЭМТ-ийн 2021 оны бараа материалын тодруулга тайлангийн эмийн зарцуулалтын орлого, зарлагын дүнг харилцагч байгууллагын нэхэмжлэх дүнгээр түүвэрлэн шалгахад 926260 төгрөгийн анхан шатны баримтын бүрдэлт дутуу, үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй зөрүүтэй тайлагнасан зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.”, НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.”, 13 дугаар зүйлийн 6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.”, 13 дугаар зүйлийн 7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.”, 20 дугаар зүйлийн 2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь:
Албан шаардлага бичлээ.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нэг удаагийн тэтгэмжтэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Нэг удаагийн тэтгэмж урамшуулалын зардлаас 700.0 мянган төгрөгийн материал худалдан авсан.

1.2. Өгсөн зөвлөмж:

Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал, ашиглах заавар”-ын дагуу зарцуулалт хийж ажиллах.

2. Хөрөнгийн тооллоготой холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Олон жил хадгалагдаж, цаашид ашиглагдахгүй байгаа үндсэн хөрөнгө, бараа материалыг жилийн эцсийн хөрөнгийн тооллогоор акталж устгах ажил хийгдээгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Байгууллагын хагас бүтэн жилийн хөрөнгө, материалын тоологыг чанартай үр дүнтэй зохион байгуулж, ашиглагдахгүй байгаа хөрөнгө, материалыг акталж устгах ажлыг зохион байгуулж ажиллах.

3. Шилэн данстай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Шилэн дансанд мэдээлсэн мэдээлээс 10 мэдээлийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

3.2. Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хуулинд заасан хугацаанд мэдээллийг бүрэн мэдээлж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 02 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/ д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа зөрчлийн дүн		/сая/төгрөгөөр/ Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Могод сумын ЭМТ	9	58.1	3	55.7	2	0.8	1	0.9	3	0.7

